



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 06

Мөрөн

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн цалин тогтоох,  
2021 оны зардал батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.5 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын сард олгох цалингийн хэмжээг 01 дүгээр, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлыг 38,229,200 (Гучин найман сая хоёр зуун хорин есөн мянга хоёр зуун) төгрөгөөр тогтоож 02 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан цалинг 2021 оны 01 дүгээр сараас эхлэн ажлын тайлан үр дүнг дүгнэж, тооцож олгохыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд), Компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Компанийн удирдлагын зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

110150013

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны  
өдрийн 06 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт




“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

№	Албан тушаал	Үндсэн цалин /төгрөг/
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	260,000
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	200,000
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	800,000

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны  
өдрийн 06 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт



“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ТУЗ-ИЙН 2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал
1	Цалингийн зардал	31,920,000
2	НДШ	4.309.200
4	Шуудан холбоо	300,000
5	Бичиг хэргийн зардал	900,000
6	Хурлын зардал	800,000
	ДҮН	38,229,200

оОо